



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Үндэсний их баяр наадмын үеэр бэлэн
байдлыг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль дахин зарлагдаж, Тулгар төр байгуулагдсаны 2226, Их монгол улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн Үндэсний их баяр наадам тохиож 9 хоног бүх нийтээр амрахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зам, тээврийн салбарын нийт төрийн байгууллага, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой байгууллагын дарга, захирал нарт даалгасугай:

1. Иргэний нисэхийн ерөнхий газарт:

1.1. Агаарын тээврийн дэд бүтэц, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналтыг чангатган, сахилга хариуцлагыг өндөржүүлж ажиллах, бэлэн байдлыг шалгах;

1.2. Агаарын тээврийн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, олон улсын болон орон нутгийн зорчигч тээврийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны шуурхай тасралтгүй байдлыг хангуулж, зорчигч үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүйгээр зохион байгуулах;

1.3. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын агаарын хөлгийн шатахуун хангамжийн барилга байгууламж, агуулахын сав, гидрант систем, тоног төхөөрөмжүүд болон хадгалалтад байгаа шатахууныг техникийн тодорхойлолт, стандарт шаардлагын дагуу хүлээн авч, шатахууны чанарын хяналт, өдөр тутмын үзлэг шалгалт, байгууламжийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах;

2. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т:

2.1. Баяр наадмын үеэр зорчигч урсгал нэмэгдэхтэй холбогдуулан үйлчилгээнд ямар нэгэн чирэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах, зорчигчдын ая тухтай байдлыг бүрэн хангаж үйлчлэх;

2.2. Улс, хот хоорондын болон ачаа, зорчигч тээврийн нийт аж ахуйн нэгж, тээвэрлэгч жолооч нарт цаг агаарын гэнэтийн үзэгдэл, бороо уснаас үүссэн замын эвдрэл, гэмтлээс болгоомжтой зорчих, гарц, гарамгүй газраар дур мэдэн гол, ус гатлахгүй байх, хөдөлгөөний хурд хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг урьдчилан анхааруулж, тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдалд тогтмол хяналт тавьж ажиллах;

2.3. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зорчигчдод цаг агаарын нөхцөл байдлын талаарх мэдээлэл, сурталчилгаа хүргэж, албан ёсны зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээ авах;

2.4. Тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн бэлэн байдал, цагийн хуваарь, замналыг баримталж ажиллах, осол зөрчлөөс сэргийлэх чиглэлээр үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах, үүрэг, даалгавар биелүүлж ажиллаагүй тохиолдолд гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах;

3. “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК-д:
- 3.1. Баяр наадмын амралтын хугацаанд төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зорчигч, ачаа тээврийн хөдөлгөөнийг тасралтгүй зохион байгуулах;
- 3.2. Байгалийн онц аюултай үзэгдэл болсон тохиолдолд тээврийн хөдөлгөөнийг тасалдуулахгүй байх зорилгоор бэлтгэл хангах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар ажил зохион байгуулах;
- 3.3. Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг чанд сахиулж, харуул хамгаалалтыг сайжруулах;
- 3.4. Замын хэмжээнд амралтын өдрүүдэд гэнэтийн эргүүл шалгалт хийх, ажилчдын сахилга батыг хангуулах арга хэмжээ зохион байгуулах;
- 3.5. Зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг бүрэн хангах, ачаалал нэмэгдэхтэй холбоотой үйлчилгээнд ямар нэгэн чирэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т:
- 4.1. Авто замын бэлэн байдлыг хангуулах талаар зам хариуцагч байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж мэдээллийг шуурхай авч ажиллах;
- 4.2. Улсын чанартай авто замын засвар арчлалт хариуцсан байгууллагуудад цаг агаарын мэдээ болон болзошгүй үер усны аюулын тухай урьдчилан мэдэгдэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;
- 4.3. Бүс нутаг хариуцсан хяналтын инженерүүдийг бэлэн байдлын хугацаанд байнгын хяналт тавьж ажиллуулах.

5. Далайн захиргаанд:
- 5.1. Зорчигч урсгал нэмэгдсэн үед усан замаар тээвэр эрхлэгчдэд тавих хяналтыг нэмэгдүүлж аюулгүй байдлыг хангуулах, баяр наадмын үеэр Хөвсгөл нууранд хүч нэмэгдүүлэн ажиллах;
- 5.2. Орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран усанд хүн эндэхээс сэргийлж анхааруулга гаргах, хамтарсан хяналтын ажил зохион байгуулах;

6. Баяр наадмын үеэр байгууллага тус бүр хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж цаг үеийн нөхцөл байдал, авсан арга хэмжээний талаарх шуурхай мэдээллийг өдөр бүрийн 8:00-20:00 цагийн хооронд 2 цаг тутам Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцлагатай жижүүрт ирүүлэхийг “Иргэний нисэхийн ерөнхий газар” /Л.Бямбасүрэн/, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /П.Дэлгэрнаран/, Далайн захиргаа /С.Түвшинтөр/, “Улаанбаатар төмөр зам” ХНН /Д.Жигжиднямаа/, “Монголын төмөр зам” ТӨХК /Х.Хэрлэн/-д тус тус даалгасугай.

Хоёр. Хариуцсан салбар тус бүрийн аюулгүй ажиллагаа, бэлэн байдалд хяналт тавьж, аливаа тулгамдсан асуудлыг шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг яамны салбар хариуцсан газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, баяр наадмын үед гүйцэтгэсэн ажлын талаар яамны удирдлагад 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД  Д.ГАНБАТ

